

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

---

2007 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Заавар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, хэлбэрийн заавар”-ыг нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ДААТГАГЧИЙН САНХҮҮГИЙН НЭМЭЛТ  
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, ХЭЛБЭРИЙН ЗААВАР**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү зааврын зорилго нь Даатгалын тухай хуулийн 29.3 дугаар заалтын дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа ердийн даатгалын компанийн санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэрийг тогтооход оршино.

1.2. Энэхүү заавар нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 4, Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан журам, зааврын хүрээнд мөрдөгдөнө.

**ХОЁР. Санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэр**

2.1. Сангийн сайдын 2004 оны 284 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Санхүүгийн тайлан тэнцлийн үлдэгдэл балансын хөрөнгийн эх үүсвэрийн урт хугацаат өр төлбөр гэсэн бүлэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 23 тоот тогтоолоор баталсан “Нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасан орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, нэхэмжилсэн хохирлын нөөц сан, учирч болзошгүй хохирлын нөөц сангуудын үлдэгдлийг тус бүрээр нь бичнэ.

2.2. Орлогын тайланг энэ зааврын 1 дүгээр хавсралтаар гаргана.

2.3. Дүрмийн сангийн тайланг энэ зааврын 2 дугаар хавсралтаар гаргахдаа Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгагчийн нөөц болон дүрмийн сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмын дагуу байршуулсан чиглэл тус бүрээр тусгасан байна.

2.4. Даатгалын нөөц сангийн тайланг энэ зааврын 3 дугаар хавсралтаар гаргана.

2.5. Даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр тайланг энэ зааврын 4 дүгээр хавсралтаар гаргана.

**ГУРАВ. Бусад**

3.1. Даатгалын компани аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлж байна.

“Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн  
агуулга, хэлбэрийн заавар”-ын 1 дүгээр хавсралт

Орлогын тайлан  
.... оны... сар

(Аж ахуйн нэгжийн нэр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хэсгийн дүн	Дүн	Бүлгийн дүн
1.1	Даатгалын хураамж			
1.1.1	давхар даатгалын хураамж			
1.1.2	буцаасан даатгалын хураамж			
1.2.	Даатгалын цэвэр хураамж			
1.2.1	орлогод тооцоогүй хураамжийн нөөц			
1.2.2	орлогод тооцсон хураамж			
1.2.2.1	нэхэмжилсэн хохирлын нөөц			
1.2.2.2	гарч болзошгүй хохирлын нөөц			
1.2.2.3	даатгалын нөхөн төлбөр			
1.3.	Даатгалын орлого			

Захирал...../

/

Нягтлан бодогч...../

/

“Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн  
агуулга, хэлбэрийн заавар”-ын 2 дугаар хавсралт

Дүрмийн сангийн тайлан  
..... оны.....сар

(Аж ахуйн нэгжийн нэр)  
Дүрмийн сангийн байршил

Эхний  
үлдэгдэл

Эцсийн  
үлдэгдэл

Өөрчлөлт

1. Дүрмийн сан
2. Байршил
  - 2.1. мөнгөн хөрөнгөөр
    - 2.1.1 бэлэн мөнгө
    - 2.1.2 харилцах
    - 2.1.3 хадгаламж
    - 2.1.4 бусад
  - 2.2. хөрөнгө
    - 2.2.1. үл хөдлөх хөрөнгө
    - 2.2.2. бараа материал
    - 2.2.3. бусад
  - 2.1 биет бус хөрөнгө
    - 2.3.1 үнэт цаас
    - 2.3.2 хувьцаа
    - 2.3.3 бусад
  - 2.2 Зарцуулалт
    - 2.4.1 хохирол нөхөлт
    - 2.4.2 бусад хасагдуулга

Захирал..... /  
Нягтлан бодогч..... /

/  
/

“Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн  
агуулга, хэлбэрийн заавар”-ын 3 дугаар хавсралт

Даатгалын нөөц сангийн тайлан  
..... оны .... сар

(Аж ахуйн нэжийн нэр)

Нөөц сангууд	Эхний үлдэгдэл	өөрчлөлт нэмэгдсэн	хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц				
Нэхэмжилсэн хохирлын нөөц				
Учирч Хураамжийн болзошгүй				
хохирлын нөөц Бусад	Хxxxxxxx		xxxxxxx	
ДҮН				

Захирал...../ /  
Нягтлан бодогч ...../ /

“Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн  
агуулга, хэлбэрийн заавар”-ын  
4 дүгээр хавсралт

Даатгалын хураамжийн орлого  
Нөхөн олговрын тайлан  
..... оны .... сар

(Аж ахуйн нэжийн нэр)

д/д	Даатгалын хэлбэр	Даатгалын үнэлгээ	Хураамжийн орлого	Олгосон нөхөн олговор	Төлбөр хийгдээгүй нэхэмжилсэн нөхөн олговор	Давхар даатгалын хураамж
-----	---------------------	----------------------	----------------------	-----------------------------	--	--------------------------------

Захирал...../ /  
Нягтлан бодогч ...../ /